



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/205

Булган сум

**Онцгой байдлын газарт техник хэрэгсэл
худалдан авахад хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4 дэх заалт, 3.4 дэх хэсэг, Улсын Онцгой комиссын 2025 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Онцгой байдлын газраас ой, хээрийн гал түймрийн хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах зорилгоор техник хэрэгсэл худалдан авахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах зардалд 19,980,000 (арван есөн сая есөн зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх техник хэрэгслийг худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулж, байгууллагын данс бүртгэлд тусгаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Н.Хишигдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 31-ны ний өдрийн А/105 дүгээр
захирамжийн хавсралт

ХОЛБОО, ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Бараа бүтээгдэхүүний нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Сансрын интернэт холбоо (Starlink)	1	5.500.000	5.500.000
2	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)	1	5.880.000	5.880.000
3	Хэт богино долгионы гар станц	40	215.000	8.600.000
	Нийт	-	-	19.980.000